

**“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС”
ХУВЬЦААТ КОМПАНИ**

2018 оны 11 сарын 24 өдөр

№ 0101

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Тайлан батлах
тухай

“Мандалговь-Импекс” ХК-ийн 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын /№1/ тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан , Аудитын хорооны тайлан , ТУЗ-ийн тайланг баталсугай.
2. “Мандалговь-Импекс” ХК-ийн цаашдын үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллахыг ТУЗ-ийн дарга-/Ө.Будханд/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

**“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС”
ХУВЬЦААТ КОМПАНИ**

18 4 27
20...оны...сарын...өдөр

№ 02

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг батлах
тухай

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75,4 дэхь заалт, хувьцаа эзэмшигчдийн санал, тооллогын комиссын /№2/ тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

Тус компанийн ТУЗ-ийн гишүүнд:

1. Д.Ганболд	52612	ширхэг саналаар буюу 100 хувь
2. Д.Хуушаан	52612	ширхэг саналаар буюу 100 хувь
3. Д.Мөнхсайхан	52612	ширхэг саналаар буюу 100 хувь
4. А.Цэцэгдэлгэр	52612	ширхэг саналаар буюу 100 хувь
5. Ч.Тогтохбаяр	52612	ширхэг саналаар буюу 100 хувь
6. Ө.Будханд	52612	ширхэг саналаар буюу 100 хувь

ТУЗ-ийн хараат бус гишүүнд.

1. Б.Гантулга	52612	ширхэг саналаар буюу хувь
2. С.Содбаатар	52612	ширхэг саналаар буюу хувь
3. С.Дарханбаатар	52612	ширхэг саналаар буюу хувь

тус тус сонгогдсон тул ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацааг хувь нийлүүлэгчдийн дараагийн хурал хүртэл баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

“Мандалговь-Импекс” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн
ээлжит хурлын тэмдэглэл

2018-04-24

Улаанбаатар хот

“Мандалговь-Импекс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018-04-24-ны өдрийн 15:00 цагт “Монгол савхи” ХК-ийн хурлын танхимд хуралдлаа. Хурлыг Д.Мөнхсайхан даргалав.

Хурлын дарга Д.Мөнхсайхан: Монгол улсын компанийн тухай хуульд заасан дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг товолж өнөөдөр хурлаа хийх гэж байна. Бүх БДК-уудад хурлын материалыг хүргүүлсэн ба олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр хуульд заасан хугацаанд зарыг тавьсан. Одоо хурлын дэгийг танилцуулъя. Та бүхэнд хурлын дэгийн талаар санал хүсэлт байна уу?

Хуралд оролцогчдын 100 хувийн саналаар хурлын дэгийг баталлаа. Нарийн бичгийн дарга С.Батбилэг хурлын ирцийг танилцуулав.

С.Батбилэг: “Мандалговь-Импекс” ХК-ийн хувьцааны 52612 ширхэг хувьцааг эзэмшигч 9 хувьцаа эзэмшигч хуралд хүрэлцэн ирсэн ба 73,71 хувийн ирцтэй байна. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтад заасан үндэслэлээр хурлын ирц хангагдсан байна.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

-Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан

-Компанийн ТУЗ-ийн 2017 оны тайлан

-Аудитын хорооны тайлан

-ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Хурлын дарга Д.Мөнхсайхан: Хурлын дэгийн дагуу компанийн 2017 оны үйл ажиллагааны тайланг Ө.Будханд танилцуулна гэв.

Ө.Будханд: Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайланг танилцуулав.

Хурлын дарга Д.Мөнхсайхан: Тайлантай холбогдуулж асуух тодруулах зүйл байвал асууя гэв.

А.Цэцэгдэлгэр: Жилээс жилд үйл ажиллагаа чинь муудаад байна уу даа?

Ө.Будханд: Орон нутгийн хүн амын амьжиргаа муу, хүн ам цөөн, зах зээл байхгүй, хөрөнгө оруулалт хийгээд тэр нь эргээд гараад ирнэ гэхэд хэцүү. Байдал үнэхээр хэцүү байна. Жил болгон л энэ талаар ярьдаг шийдсэн дорвитой зүйл алга, хийх гэхээр эдийн засгийн байдал маш муу байна.

Хурлын дарга Д.Мөнхсайхан: Хурлын дэгийн дагуу одоо ТУЗ-ийн тайланг сонсоё.

Ө.Будханд: Компанийн ТУЗ-ийн 2017 оны тайланг танилцуулав.

А.Цэцэгдэлгэр: Одоо хэдэн хүн ажиллаж байгаа юм бэ?



Ө.Будханд: Одоо 5 хүн л ажиллаж байгаа. Ямар нэгэн өр ширний асуудалгүй байна. Хөрөнгийн биржийн хуримтлагдсан өрийг өгсөн. Үнэндээ орлого муу учраас зарим зардалыг өөрөөсөө гаргадаг. Одоо гаргах гээд ч гаргах чадал байхгүй болж байна.

Хурлын дарга Д.Мөнхсайхан: Аудитын дүгнэлтийг А.Цэцэгдэлгэр танилцуул гэв.
А.Цэцэгдэлгэр: Аудитын дүгнэлтийг танилцуулав.

Хурлын дарга Д.Мөнхсайхан: Асууж тодруулах зүйл байвал асууя гэв.

А.Цэцэгдэлгэр: Будханд хувийхаа зүгээс өвөл нүүрс авч өгдөг юм байна. Зарим нэг зардалыг дан хувиасаа гаргадаг юм банья. Яагаад баланс тайлан дээр үүнийгээ тусгахгүй байна. Танай тайланг харахад орлого зарлага яг тэнцүү байна..

Ө.Будханд: Тиймээ, орон тооны нягтлан байхгүй нэг хүн гуйж тайлангаа гаргуулдаг. Ёстой үнэхээр хэцүү байна. Энэ компаний асуудлыг нэг тийш нь шийдэж өгмөөр байна.

Д.Хуушаан: Сахилга хариуцлага тоцдог болмоор байна. Хуучнаар явдаг системийг сэргээх хэрэгтэй. Цэцэгдэлгэр үүнийг удирдан зохион байгуулж ажил хэрэг болгох хэрэгтэй.

Хурлын дарга Д.Мөнхсайхан: За одоо дэгийн дагуу санал хураах үйл ажиллагаа явуулъя.

Н.Болормаа: Санал хураалтын дүнг тооллогын комисс нэгтгэж, тогтоолын төслийг танилцуулав.

1. Саналын хуудсаар компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн тайлан, Аудитын хорооны тайланг хувьцаа эзэмшигчид 100 хувь зөвшөөрсөн байна.

2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Д.Ганболд, Д.Хуушаан, Д.Мөнхсайхан, Ч.Тогтохбаяр, Ө.Будханд, А.Цэцэгдэлгэр 5845 ширхэг санал буюу 100 хувь, хараат бус гишүүнд нэр дэвшигч Б.Гантулга, С.Дарханбаатар С.Содбаатарт 5845 ширхэг санал буюу 100 хувь тус тус санал авав.

Хурлын дарга Д.Мөнхсайхан: “Мандалговь-Импекс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төслүүдийг танилцуулж баталлаа.

1. Тогтоол №1 Тайлан батлах /2017 оны үйл ажиллагааны тайлан, Аудитын хорооны тайлан, ТУЗ-ийн тайлан/

2. Тогтоол №2 ТУЗ-ийн гишүүдийг батлах

Хурлыг 16 цагт хаав.

Хянасан: Хурлын дарга

Д.Мөнхсайхан

Тэмдэглэл хөтөлсөн:

С.Батбилэг

**“Мон-Ит Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
ТОГТООЛ**

2018.04.27

№ 01

Улаанбаатар хот

Дүгнэлтийг сайшаах тухай

“Мон-Ит Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Мон-Ит Булигаар” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг сайшаасугай.
2. “Мон-Ит Булигаар” ХК-ийн 2018 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг компанийн ТУЗ-д үүрэг болгосугай.

Хурлын дарга



Д.Ганболд

**“Мон-Ит Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
тооллогын комиссын тогтоол**

2018.04.27

№ 02

Улаанбаатар хот

ТУЗ-ийн гишүүнээр сонгох тухай

“Мон-Ит Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон гишүүдийн саналын хуудсаар өгсөн саналын тоог үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн гишүүн:

Дархижав Ганболд	346325
Пунцаг Мөнхчулуун	346325
Сэрээтэр Ундармаа	346325
Чулуунбаатар Тогтохбаяр	346325
Өөдөс Мөнхтайван	346325
Мөнхбаяр Мөнхбаясгалан	346325

2. ТУЗ-ийн Хараат бус гишүүн:

Чойжил Жаргалсайхан	346325
Дамдинсүрэн Мөнхбат	346325
Баттулга Төгсжаргал	346325 саналаар тус тус сонгогдсоныг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан батлуулсугай.

Тооллогын комиссын дарга
Гишүүн



Ч.Жаргалсайхан

Ч.Тогтохбаяр

**“Мон-Ит Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
ТОГТООЛ**

2018.04.27

№ 03

Улаанбаатар хот

ТУЗ-ийн гишүүнээр батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.2 дахь заалт, 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Мон-Ит Булигаар” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын №02 тоот тогтоолыг үндэслэн тус компанийн ТУЗ-ийн гишүүнээр Д.Ганболд, П.Мөнхчулуун, С.Ундармаа, Ч.Тогтохбаяр, Ө.Мөнхтайван, М.Мөнхбаясгалан, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Ч.Жаргалсайхан, Д.Мөнхбат, Б.Төгсжаргал нарыг баталсугай.
2. “Компанийн тухай хууль”-ийн 76, 78 дугаар зүйл, компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийг тус тус удирдлага болгож, бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллахыг ТУЗ-д даалгасугай.

Хурлын дарга



Д.Ганболд

“МОН-ИТ БУЛИГААР” ХУВЬЦААТ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018.04.27

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Өнөөдөр сонины 2018 оны 03 дугаар сарын 26, 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр дахин давталттайгаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэв.

Хурлыг 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 09:00 цагт Улаанбаатар хот ХУД 2 хороо Арьс ширний үйлдвэрийн хашаанд байрлах компанийн байранд хуралдуулав.

Хурлын даргаар ТУЗ-ын дарга Д.Ганболдыг сонгов.

Хурлын дарга Д.Ганболд: Ирцийг танилцуулна уу тооллогын комисс.

Ч.Тогтохбаяр: Тус компанийн нийт хувьцааны 195.996 ширхэг буюу 48,9 хувийг эзэмшигч Ж.Одонбаярын итгэмжлэлтэй Г.Мөнхбилэг, 150.329 ширхэг буюу 37,5 хувийг эзэмшигч О.Уянзаяа нар хүрэлцэн ирж хурлын ирц 86,4 хувьтай байна.

Д.Ганболд: за ойлгомжтой.Хуралд хувьцаа эзэмшигчдийн дийлэнхи хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирсэн байна.Компанийн тухай хуулийн 69.1-д зааснаар хурлыг эхлэе.

Хуралд дараахи асуудлыг хэлэлцүүлэхээр санал оруулж байна.Үүнд:

Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгож батлах.

Д.Ганболд: Гүйцэтгэх захирал М.Мөнхбаясгалангийн 2017 оны үйл ажиллагааны тайлантай танилцаа.

Тайланг танилцуулав.

Д.Ганболд: Тайлантай холбогдуулж хувьцаа эзэмшигчдэд асуух асуулт байна уу?

Ч.Жаргалсайхан: Тайлангаас харахад өмнөх жилүүдээс үйл ажиллагаа илт сайжирсан байна.Түүхий эд бэлтгэл болон бусад үйл ажиллагаанд идэвхи санаачилгатай ажилласан нь харагдаж байна.Өмнөх жилүүдэд үүсээд байсан өр төлбөрийн асуудлын тодорхой хэсэг нь шүүхээр яваад шүүхийн шатанд ялалт байгуулсан нь сайшаалтай байна.

О.Уянзаяа: Гадаад харилцаа талдаа ач холбогдол өгч Герман руу хромгүй байгал орчинд ээлтэй технологиор арьс боловсруулж туршилтаар дээж явуулсан нь хүлээн авагч талынхаа шаардлагыг хангасан гэж байна.Энэ бол миний бодлоор маш сайн.Эцсийн бүтээгдэхүүн хийгээд Европын зах зээлд нийлүүлэх суурь тавигдаж байгаа юм байна гэж бодлоо.

М.Мөнхбаясгалан: Тийм.Ер нь бол үйлдвэр маань Монгол улсдаа төдийгүй Азидаа томд орох үйлдвэр.Бид Герман болон Финлянд руу ямаа, үхрийн арьсыг бүтэн боловсруулалт хийж, дээжинд өгч явуулсан захиалагч талын шаардлагыг бүрэн хангасан байгаа.Удахгүй энэ асуудал үйлдвэрлийн шатанд шилжинэ гэж тооцоолж байгаа.

Г.Мөнхбилэг: Сайн байна.Өөр клиент харилцагчтай болж чадаж байгаа юу? Дотоодын зах зээлд юу хийх гэж байна.?

М.Мөнхбаясгалан: Дотоодын зах зээлд бид гялгар хром болон булигаар дээр бүрэн боломж бий. Мөн Хонг Конг руу дээжинд үхрийн хагас боловсруулсан хөх шир явуулсан байгаа.Хариу нь удахгүй ирнэ.

Д.Ганболд: За дараагийн асуудалдаа ороё. ТУЗ-ийн гишүүдийг сонгох талаар хүмүүсийн нэрийг саналын хуудсанд оруулсан байгаа.Хувьцаа эзэмшигч О.Уянзаяа та болон, Ж.Одонбаярын итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Мөнхбилэг та саналаа өгнө үү.

Тооллогын комиссын дарга ТУЗ-ийн гишүүдийг сонгох сонгуулийн үр дүнг танилцуулав.
Хуралд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүдээр доорхи хүмүүсийг батлав.

1. Д.Ганболд	346325
2. П.Мөнхчулуун	346325
3. Ч.Тогтохбаяр	346325
4. С.Ундармаа	346325
5. М.Мөнхбаясгалан	346325
6. Ө.Мөнхтайван	346325
7. Д.Мөнхбат / хараат бус/	346325
8. Ч.жаргалсайхан /хараат бус/	346325
9.Б.Төгсжаргал / хараат бус/	346325 саналаар.

Хурлын шийдвэр:

Хурлаар хэлэлцсэн асуудалтай холбогдож гарах тогтоолын төслийг хэлэлцэж батлав.

Хурал 10 цаг 50 минутад дуусав

Танилцсан:Хурлын дарга

Тэмдэглэл хөтлөсөн.



Д.Ганболд

Ц.Тувшинбаяр